



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цагдаагийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2022/196/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улиастай сум 2022 он</p>	<p>Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа Утас: 99993365 Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn</p> <p>Аудитын менежерийн үүрэг гүйцэтгэгч : Г.Заяа Утас:92038288 Цахим хаяг: zayag@audit.gov.mn</p> <p>Аудитор Б.Жалбаа Утас: 89330330 Цахим хаяг: jalbaab@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
3. Аудитын тайлан	11
3.1 Ерөнхий зүйл	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	14
3.8 Аудитын гол асуудал	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
4. Аудитын илрүүлэлт	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ЗАВХАН АЙМГИЙН ЦАГДААГИЙН
ГАЗРЫН ДАРГА Н.ОТГОНЖАРГАЛ-д

**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

81000 Уластай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12

данд. 02.16 № 1302/44
Танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цагдаагийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цагдаагийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

013022912

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл
нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн
шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

СТ-1А

/мян.төг\

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	246,200.6	237,424.8
35	БАРАА МАТЕРИАЛ	246,200.6	237,424.8
351	Түүхий эд материал	118,222.3	126,182.5
35110	Тусгай зориулалттай материал	117,124.7	125,015.6
35130	Эм боох материал	1,097.7	1,166.9
35300	Бэлэн бүтээгдэхүүн	1,994.4	1,901.4
354	Хангамжийн материал	124,884.0	109,340.9
35410	Бичиг хэргийн материал	24,000.6	9,467.7
35420	Аж ахуйн материал	19,895.7	20,284.0
35440	Түлш, шатах тослох материал	35,828.5	23,326.1
35450	Барилгын засварын материал	14,997.3	20,331.3
35460	Хүнсний материал	1,537.9	2,958.6
35470	Бусад хангамжийн материал	28,623.9	32,973.2
35600	Мал амьтад	1,100.0	.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5,841,031.5	5,818,986.0
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,841,031.5	5,818,986.0
392	Биет хөрөнгө	5,492,276.1	5,338,778.6
39201	Барилга, байгууламж, орон сууц	5,162,786.6	5,162,786.6
39202	Хуримтлагдсан элэгдэл	-345,677.7	-552,455.5
39203	Авто-тээврийн хэрэгсэл	594,378.5	739,655.4
39204	Хуримтлагдсан элэгдэл	-277,014.7	-357,890.0
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	447,078.2	529,897.0
39206	Хуримтлагдсан элэгдэл	-202,288.3	-305,325.3
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	121,531.5	124,531.5
39208	Хуримтлагдсан элэгдэл	-71,321.7	-84,434.1
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	57,264.8	57,264.8
39214	Бусад үндсэн хөрөнгө	15,897.6	37,666.6
39215	Хуримтлагдсан элэгдэл	-10,358.7	-12,918.4
393	Биет бус хөрөнгө	348,755.4	480,207.4
39301	Програм хангамж	550.0	550.0
39302	Хуримтлагдсан элэгдэл	-297.9	-550.0
39303	Бусад биет бус хөрөнгө	348,503.4	480,207.4
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	6,087,232.2	6,056,410.8
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	6,087,232.2	6,056,410.8
51	Засгийн газрын хувь оролцоо	6,087,232.2	6,056,410.8
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,993,276.6	2,124,980.6
51101	Өмч: - төрийн	1,993,276.6	2,124,980.6
512	Хуримтлагдсан үр дүн	2,500,283.3	2,337,757.9
51210	Өмнөх үеийн үр дүн	2,500,283.3	2,500,283.3
51220	Тайлант үеийн үр дүн	.0	-162,525.4
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,593,672.2	1,593,672.2
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	6,087,232.2	6,056,410.8

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

СТ-2А

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,774,602.1	4,138,442.2
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	339,910.1	381,746.2
120	Нийтлэг татварын бус орлого	339,400.8	381,746.2
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	82,899.9	84,050.3
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	76,837.1	80,877.8
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	6,062.9	3,172.5
120017	Үнэ төлбөргүй орсон орлого Үндсэн хөрөнгө	222,365.9	249,834.7
120018	Үнэ төлбөргүй орсон орлого Бараа материал	34,134.8	47,861.2
122	Тусламжийн орлого	509.3	.0
122001	Хандив тусламж /дотоод/	509.3	.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,434,692.0	3,756,696.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,382,857.9	3,635,831.2
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,382,857.9	3,635,831.2
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	51,834.1	120,864.8
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	.0	30,000.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	51,834.1	90,864.8
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,988,140.8	4,299,717.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,988,140.8	4,299,717.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,968,819.8	4,280,339.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,939,756.7	3,112,301.1
210101	Үндсэн цалин	2,201,200.8	1,763,550.2
210102	Нэмэгдэл	738,555.8	1,311,490.4
210105	Гэрээт ажлын хөлс	.0	37,260.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	69,303.3	72,335.5
210201	Тэтгэврийн даатгал	8,761.7	8,172.4
210202	Тэтгэмжийн даатгал	1,031.1	906.4
210203	ҮОМШӨ-ний даатгал	824.9	725.2
210204	Ажилгүйдлийн даатгал	200.5	162.7
210205	Эрүүл мэндийн даатгал	58,485.2	62,368.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	155,599.8	153,862.5
210301	Гэрэл, цахилгаан	42,822.9	45,156.7
210302	Түлш, халаалт	104,158.1	95,079.3
210303	Цэвэр, бохир ус	8,618.8	13,626.5
2104	Хангамж, бараа материалын зардал	205,564.9	320,261.2
210401	Бичиг хэрэг	12,231.4	41,905.4
210402	Тээвэр, шатахуун	152,348.2	217,067.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	14,681.1	12,633.3
210404	Ном, хэвлэл	.0	5,000.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	650.2	660.0

Цагдаагийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,150.1	28,317.2
210408	Бараа материал акталсны зардал	18,503.9	14,678.3
2105	Нормативт зардал	37,286.5	39,644.5
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	131.5	304.7
210502	Хоол, хүнс	35,865.1	37,809.8
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,290.0	1,530.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	40,826.5	78,409.2
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,117.5	3,078.2
210604	Урсгал засвар	36,709.1	75,331.0
2107	Томилолт, зочны зардал	7,747.0	5,065.0
210702	Дотоод албан томилолт	7,747.0	5,065.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,170.7	6,206.5
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,321.5	1,064.9
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,520.0	1,900.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,905.0	1,727.1
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	638.0	640.0
210807	Газрын төлбөр	600.0	600.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	186.2	274.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	503,564.2	492,254.2
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	.0	33,272.9
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,600.2	32,617.0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	489,964.0	426,364.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19,320.9	19,377.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,260.0	4,500.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	500.0	500.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,760.0	4,000.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	14,060.9	14,877.9
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,045.1	14,877.9
213305	Төвлөрүүлэх шилжүүлэг нэмэлт	15.8	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-213,538.7	-161,275.4
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	34,396.9	1,250.0
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	34,396.9	1,250.0
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-34,396.9	-1,250.0
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-247,935.6	-162,525.4

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН					СТ-4А
					/ мян.төг /
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,993,276.6	1,679,172.6	416,765.2	4,089,214.4
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.0	0.0	1,464.7	1,464.7

Цагдаагийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,993,276.6	1,679,172.6	418,229.9	4,090,679.1
C07	Тайлант үеийн үр дүн	0.0	0.0	2,245,953.3	2,245,953.3
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,993,276.6	1,593,672.2	2,500,283.3	6,087,232.2
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,993,276.6	1,593,672.2	2,500,283.3	6,087,232.2
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.0	0.0	0.0	0.0
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,993,276.6	1,593,672.2	2,500,283.3	6,087,232.2
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	131,704.0	0.0	0.0	131,704.0
D08	Тайлант үеийн үр дүн	0.0	0.0	-162,525.4	-162,525.4
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,124,980.6	1,593,672.2	2,337,757.9	6,056,410.8

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

СТ-2А

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/мян.төг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	3,512,682.3	3,837,573.8
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	3,511,332.6	3,813,543.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,511,332.6	3,813,543.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,492,011.7	3,794,165.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,939,719.0	3,144,360.1
210101	Үндсэн цалин	1,845,240.7	1,795,609.2
210102	Нэмэгдэл	1,061,319.0	1,311,490.4
210105	Гэрээт ажлын хөлс	33,159.3	37,260.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	69,341.0	72,337.4
210205	Эрүүл мэндийн даатгал	69,341.0	72,337.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	143,549.2	149,359.7
210301	Гэрэл, цахилгаан	42,822.9	45,606.7
210302	Түлш, халаалт	92,107.5	90,126.5
210303	Цэвэр, бохир ус	8,618.8	13,626.5
2104	Хангамж, бараа материалын зардал	215,713.2	248,302.7
210401	Бичиг хэрэг	18,820.5	33,123.0
210402	Тээвэр, шатахуун	158,528.4	176,064.9
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	15,206.1	12,819.0
210404	Ном, хэвлэл	50.0	5,120.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	650.2	660.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	22,458.0	20,515.9
2105	Нормативт зардал	36,330.2	42,330.6
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	198.2	378.0
210502	Хоол, хүнс	34,632.0	40,452.6

Цагдаагийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,500.0	1,500.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	57,152.9	85,506.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,996.9	4,000.0
210604	Урсгал засвар	53,156.0	81,506.0
2107	Томилолт, зочны зардал	7,747.0	5,071.9
210702	Дотоод албан томилолт	7,747.0	5,071.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,984.5	7,045.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,321.5	2,000.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,520.0	1,900.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,905.0	1,905.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	638.0	640.0
210807	Газрын төлбөр	600.0	600.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,474.7	39,852.5
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,474.7	39,852.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19,320.9	19,377.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,260.0	4,500.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	500.0	500.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,760.0	4,000.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	14,060.9	14,877.9
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,045.1	14,877.9
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	1,349.7	24,030.0
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1,349.7	24,030.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,349.7	24,030.0
2200	Дотоод эх үүсвэрээр	1,349.7	24,030.0
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,349.7	24,030.0
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-1,349.7	-24,030.0
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	.0	.0
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	.0	.0
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	.0	.0

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

ТГ

/мян.төг /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,701,831.1	3,701,831.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,701,831.1	3,701,831.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,697,331.1	3,697,331.1

Цагдаагийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,144,360.1	3,144,360.1
210101	Үндсэн цалин	1,795,609.2	1,795,609.2
210102	Нэмэгдэл	1,311,490.4	1,311,490.4
210105	Гэрээт ажлын хөлс	37,260.5	37,260.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	72,337.4	72,337.4
210205	Эрүүл мэндийн даатгал	72,337.4	72,337.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	147,859.7	147,859.7
210301	Гэрэл, цахилгаан	45,606.7	45,606.7
210302	Түлш, халаалт	88,626.5	88,626.5
210303	Цэвэр, бохир ус	13,626.5	13,626.5
2104	Хангамж, бараа материалын зардал	188,771.0	188,771.0
210401	Бичиг хэрэг	14,761.0	14,761.0
210402	Тээвэр, шатахуун	152,111.0	152,111.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	12,819.0	12,819.0
210404	Ном, хэвлэл	120.0	120.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	660.0	660.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,300.0	8,300.0
2105	Нормативт зардал	26,850.0	26,850.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	300.0	300.0
210502	Хоол, хүнс	25,050.0	25,050.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,500.0	1,500.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	102,536.0	102,536.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	20,380.0	20,380.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,000.0	4,000.0
210604	Урсгал засвар	78,156.0	78,156.0
2107	Томилолт, зочны зардал	5,071.9	5,071.9
210702	Дотоод албан томилолт	5,071.9	5,071.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,045.0	7,045.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,000.0	2,000.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,900.0	1,900.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,905.0	1,905.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	640.0	640.0
210807	Газрын төлбөр	600.0	600.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,500.0	2,500.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,500.0	2,500.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,500.0	4,500.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,500.0	4,500.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	500.0	500.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,000.0	4,000.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,701,831.1	3,701,831.1
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,635,831.2	3,620,953.3
131001	Улсын төсвөөс санхүүжих	3,635,831.2	3,620,953.3

120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	65,999.9	80,877.8
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	65,999.9	80,877.8

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

НТ-2

НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		120,864.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ		120,864.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		120,864.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		1,500.0
210302	Түлш, халаалт		1,500.0
2104	Хангамж, бараа материалын зардал		59,531.7
210401	Бичиг хэрэг		18,362.0
210402	Тээвэр, шатахуун		23,953.9
210404	Ном, хэвлэл		5,000.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		12,215.9
2105	Нормативт зардал		15,480.6
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		78.0
210502	Хоол, хүнс		15,402.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		7,000.0
210601	Багаж, техник, хэрэгсэл		1,150.0
210602	Тавилга		2,500.0
210604	Урсгал засвар		3,350.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	37,352.5
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		37,352.5
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	120,864.8
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		120,864.8
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		30,000.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		90,864.8
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Цагдаагийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэл, тайлагнал, худалдан авалт, арвилан хэмнэлт зэрэгтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын ахлах аудитор Б.Дагвасүрэн, аудитор Б.Жалбаа нар гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Г.Заяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Цагдаагийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 37/309 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Цагдаагийн газар нь ойрын болон дунд хугацааны тогтвортой хөгжлийг хангаж, үйл ажиллагааг боловсронгуй болгох, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх таслан зогсоох ажилд орчин үеийн менежментийн хэлбэр, дэвшилтэд техник, технологийн нэвтрүүлж, үр дүнг дээшлүүлэх, иргэд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, хүний нөөцийг бэлтгэх, мэдлэг ур чадвар чадавхыг сайжруулах, иргэдийн аюулгүй, амар амгалан амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилго дэвшүүлэн ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Тус байгууллага нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг болон дотоод хяналтыг хэрэгжүүлэх журам, заавар зэргийг боловсруулж мөрдсөн байна.

Дотоод аудитын чиг үүрэг бүхий нэгж тус байгууллагад байхгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр

санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цагдаагийн газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт орлого 4,138,442.2 мянган төгрөгийн 1 хувь буюу 41,384.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувь буюу 28,969.1 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	0	0	0
Бараа материал	246,200.6	237,424.8	-8,775.8
Үндсэн хөрөнгө	5,841,031.5	5,818,985.9	-22,045.6
Нийт хөрөнгө	6,087,232.2	6,056,410.8	-30,821.4
Өр төлбөр	0	0	0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	6,087,232.2	6,056,410.8	-30,821.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	6,087,232.2	6,056,410.8	-30,821.4

Бараа материал дансны үлдэгдэл 8,775.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд цар тахалтай холбоотой бараа материалын дутагдалд орсонтой холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 22,045.6 мянган төгрөгөөр буурсан нь элэгдлийн зардал болон дараах хөрөнгийн хөдөлгөөнтэй холбоотой байна.

- ✓ Төсвийн хөрөнгөөр байгууллагын үйл ажиллагаанд шаардлагатай мотоцикль 5,380.0 мянган, дулааны тоолуур 6,500.0 мянган, ухаалаг дэлгэц 8,500.0 мянган, сэтгэл зүйчийн өрөөнд шаардлагатай тавилга болох массажны сандал 2,500.0 мянган, компьютер 650.0 мянган, буйдан 500.0 мянган төгрөг, нийт 24,030.0 төгрөгийн хөрөнгө худалдан авсан,
- ✓ Өөрийн эзэмшлийн 131,704.0 мянган төгрөгийн газрыг данс бүртгэлд тусгасан
- ✓ Төсөвт байгууллагуудаас 249,834.7 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авсан. Үүнд:
 - Баянгол дүүргийн цагдаагийн газраас 29,624.3 мянган төгрөгийн автомашин
 - Их-Уул сумын ЕБС-аас 5,785.7 мянган төгрөгийн ПАЗ автобус,

- Нийслэлийн цагдаагийн удирдах газраас 16,290.3 мянган төгрөгийн автомашин,
 - Цагдаагийн ерөнхий газрын авто баазаас 23,572.3 мянган төгрөгийн автомашин,
 - Чингэлтэй дүүргийн цагдаагийн газраас 25,624.3 мянган төгрөгийн авто машин, 393.4 мянган төгрөгийн дуут гэрлэн дохио
 - Аймгийн засаг даргын тамгын газраас 60,000.0 мянган төгрөгийн 4 автомашин, 11,770.0 мянган төгрөгийн хамгаалалтын хашаа, 9,999.0 мянган төгрөгийн фитнесийн тоног төхөөрөмж, 49,800.0 мянган төгрөгийн хурд хэмжигч,
 - ЦЕГ-ын эрүүгийн цагдаагийн албанаас 1,250.0 мянган төгрөгийн таблет,
 - ЦЕГ-ын санхүү, аж ахуйн албанаас 15,725.4 мянган төгрөгийн компьютер, принтер зэрэг байна.
- ✓ Төрийн өмчийн хорооны шийдвэрээр 21,000.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгслийг акталсан

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 30,821.4 мянган төгрөг болж буурсан нь хуримтлагдсан үр дүн 162,525.4 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 4,056,955.9 мянган, үндсэн үйл ажиллагааны орлогоос 78,000.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 4,134,955.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсөв захирагч тус байгууллагын 2021 оны төсвийн зарлагыг 3,701,831.1 мянган төгрөгөөр, санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 3,635,831.2 мянга, үндсэн үйл ажиллагааны орлогоос 65,999.9 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан нь төсвийн төслөөс 433,124.8 мянган төгрөгөөр бууруулсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 3,635,831.2 мянган төгрөгийн, үндсэн үйл ажиллагааны орлогоос 80,877.8 мянган төгрөгийн, нийт 3,716,709.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагааны зардалд 3,701,831.1 мянган төгрөгийг зарцуулж, 14,877.9 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. Энэхүү буцаан төвлөрүүлэлт нь үндсэн үйл ажиллагааны орлого давж биелсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд 120,864.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн байна. Үүнд:

- Аймгийн засаг даргын захирамжаар 23,000.0 мянган төгрөг,
- Аймгийн ИТХ-аас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд 28,500.0 мянган төгрөг,
- Улиастай сумын ЗДТГ-аас сэтгэл зүйчийн өрөөний тохижилтод зориулан 7,000.0 мянган төгрөг,
- Урьд оны давсан орлогын санхүүжилтээр 6,222.8 мянган төгрөг
- Галт зэвсэг эзэмшигчдэд үнэмлэх олгох сургалтын төлбөрийн орлого 56,142.0 мянган төгрөг байна.

Нэмэлт орлогыг зориулалтын дагуу тухайн арга хэмжээнүүдэд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Цагдаагийн ерөнхий газрын авто баазаас “Киа моторс -Монгол” ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулан авто машины парк шинэчлэл хийсэн байна. Уг ажлын хүрээнд тус байгууллагад 3 автомашин өгсөн байна.

1. 14-37 УАТ улсын дугаартай KIA.Sportage маркийн
2. 08-51 УАТ улсын дугаартай KIA Rio YB-17 маркийн
3. 14-63 УАТ улсын дугаартай KIA.Sportage маркийн суудлын автомашинууд байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллага нь санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Байгууллагын үйл ажиллагааны зардал болох тээвэр шатахуун, хүнсний материалыг нийлүүлэх бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулсан байдлыг санхүүгийн аудитаар шалгахад материаллаг алдаа зөрчилтэй асуудал илрээгүй.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 147 мэдээлэл, хугацаа хоцроосон 2 мэдээлэл байна. Шилэн дансны хуулийн хэрэгжилт хангалттай байна гэж үзлээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хуульд заасан хугацаанд НББ-ийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлэн тайлагнаж Төрийн аудитын газарт ирүүлсэн байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тус байгууллагын санхүүгийн тайланд тусгагдсан дараах асуудлуудыг дараагийн шатны аудитаар анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

1. Тус байгууллагын цалингийн сангаас тэтгэвэрт гарсан иргэнийг цалинжуулсан байна. Уг иргэн нь тухайн орон нутагт оршин суудаггүй бөгөөд “Цагдаагийн эрх ашгийг хамгаалах зөвлөл”-ийн гишүүн байна. Дээд шатны төсөв захирагчийн шийдвэрээр тус байгууллагаас цалинжиж байгаа учир дутагдалтай байна гэж үзсэн тул нэгдсэн тайлангийн хүрээнд асуудлыг шийдвэрлүүлэх санал хүргүүлж байна. Тухайн алба хаагчийн жилийн нийт цалин 9,315.2 мянган төгрөг байна.

2. Шилэн дансны цахим мэдээллийн санд албан хаагчдад сахилгын шийтгэл ногдуулсан шийдвэрийг байршуулсан нь хувь хүний эрхийг зөрчсөн үйлдэл болсон байна гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар алдаа зөрчил илрээгүй болно.

4.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар залруулах алдаа зөрчил илрээгүй болно.

4.2 Төлбөрийн акт

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар төлбөрийн акт тогтоох алдаа зөрчил илрээгүй болно

4.3 Албан шаардлага

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар албан шаардлага өгөх алдаа зөрчил илрээгүй болно

4.4 Зөвлөмж

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар зөвлөмж өгөх алдаа зөрчил илрээгүй болно

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс								
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
	Аудитаар алдаа зөрчил илрээгүй											

БОЛОВСРУУЛСАН:


АУДИТОР



Б.ЖАЛБАА

ХЯНАСАН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

АУДИТЫН МЕНЕЖЕРИЙН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Г.ЗАЯА

